

Цэргийн хэргийн хөгжлийн тухай асуудалд

Д.Ганзориг¹, Б.Баатарсүрэн²

¹ Сайнс ренж ХХК-ны гүйцэтгэх захирал, дэслэгч генерал

² Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Бодлогын дүн шинжилгээний төв

ABSTRACT

The Armed Forces play a vital role in maintaining international relations, drawing lessons from military operations during both wartime and peacetime, and continuously advancing national military development to safeguard core national interests. This paper aims to emphasize the necessity for military leaders at all levels to consistently expand their expertise in military affairs. Security assessments and forecasts by Western experts suggest a high likelihood of armed conflict in the Indo-Pacific region between 2027 and 2030. This projection signals an impending regional crisis, underscoring the urgency for military leadership in our country to enhance their knowledge, capabilities, strategic thinking, and preparedness in anticipation of emerging challenges.

Moreover, the selection and training of military commanders must align with Mongolia's defense policy. In other words, there is an increasing need to strengthen investments in human resource development in the Armed Forces. Beyond proficiency in conventional combat operations, commanders must also be equipped to engage in peacekeeping missions, coordinate local defense efforts, and manage military operations during crises. Furthermore, they should possess the administrative knowledge to lead local government units effectively. In the era of artificial intelligence, it has become imperative for military leadership to develop the capacity to critically assess and incorporate AI-generated recommendations into their decision-making processes. Such capabilities are now as essential as air.

Keywords: *Defense policy, military science development, combat readiness, terminology, military leadership mindset and attitude.*

УДИРТГАЛ

Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичиг УИХ-аар батлагдаад 10 жил болж байна. Энэ өнгөрсөн 10 жилийн хугацаанд дээрх баримт бичгийн мөрдлөгийг хэрэгжүүлж хангаж буй байгууллага, иргэд Монгол Улсад дөрвөн жилийн хугацаатай гурван Засгийн газрын нүүр үзлээ.

1.1. Баримт бичигт “Монгол Улсын батлан хамгаалах бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд улсын дотоод, гадаад аюулгүй байдлын орчин нь батлан хамгаалах зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох үндэс болно” гэж заасан.¹

¹ Монгол Улсын Батлан Хамгаалах Бодлогын Үндэс <https://legalinfo.mn/mn/detail?lawId=206917&showType=1>

Энэ баримт бичгийн 1.3-т зааснаар “Монгол Улсын батлан хамгаалах бодлогыг Монгол Улсын Зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Засгийн газар хэрэгжүүлж, Монгол Улсын Их Хурал хяналт тавина.” гэжээ. Түүнчлэн, “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд улсын дотоод, гадаад аюулгүй байдлын орчин нь батлан хамгаалах зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох үндэс болно. Тэгвэл үндэсний язгуур ашиг сонирхол гэдэг нь “3.2.»Үндэсний язгуур ашиг сонирхол»-д Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана.” гэж Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгасан байна.²

1.2. Монгол Улсын батлан хамгаалах бодлогын зорилго нь аливаа дайн, зэвсэгт мөргөлдөөнөөс ангид байж, улсыг батлан хамгаалах тогтолцоо, батлан хамгаалах бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлж, Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, оршин тогтнохуйн аюулгүй байдлыг баталгаажуулах явдал мөн”³ гэсэн. Тиймээс ч Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, оршин тогтнохуйн аюулгүй байдлыг баталгаажуулах явдалтай Зэвсэгт хүчний хөгжил уягдах нь тодорхой байна.

Монгол түмний үнэт зүйлсийг Төрийн дууллаас тогтоож үзвээс дараах 3 зүйл Монгол Улсын үнэт зүйл болж байна. Үүнд: үндэс, угсаа, хэл, соёл⁴. Өөрөөр хэлбэл Монгол хүн, Монголын ард түмэн.

Бидний мөнхийн язгуур ашиг сонирхол тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, хөгжиж дэвшиж буй эрх чөлөөт, жаргалтай Монгол орон байна. Ашиг сонирхлоо “дэлхийн шударга улстай нэгдэж хамгаална”.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг Зэвсэгт хүчнийг бүрдүүлж бэхжүүлэх замаар орон нутгийн хамгаалалтыг чадварлаг ашиглаж, Монгол Улсын язгуур ашиг сонирхол бүхий тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, оршин тогтнохуйн аюулгүй байдлыг баталгаажуулахад оролцох, дэмжлэг үзүүлэх нь Зэвсэгт хүчний үндсэн үүрэг болж байгаа билээ.

Эдгээр нөхцөл байдалд шинжилгээ хийхэд Зэвсэгт хүчин бусад дэлхийн улс орнуудтай харилцаатай байж, дайны үеийн болон тайван цагийн цэргийн бүх төрлийн ажиллагааны туршлагаас суралцаж, авах гээхийн ухаанаар хандаж, язгуур ашиг сонирхлыг хамгаалах үүднээс үндэсний цэргийн хэргийн хөгжлийг тогтмол урагшлуулж байх үүрэгтэй. Үүнийг Монгол Улсын Зэвсэгт хүчин өөрийн нөөц боломжийн хүрээнд хийсээр ирсэн. Цаашид ч хийсээр байх болно.

Оросын Холбооны Улс Украин улс хоорондын дайн, түүний идэвхтэй

² Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал <https://legalinfo.mn/mn/detail?lawId=18>

³ Монгол Улсын Батлан Хамгаалах Бодлогын Үндэс <https://legalinfo.mn/mn/detail?lawId=206917&showType=1>

⁴ Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль, Төрийн дуулал <https://legalinfo.mn/mn/detail?lawId=496>

үе идэвхтэй цэргийн байлдааны ажиллагаагаар 2022 оны 02 дугаар сараас илэрхийлэгдэж цэргийн болон улс төр судлаачдын судалгааны объект болоод байна.

Эдгээр судлаачид энэ дайныг олон талаас нь судалж, өөрсдийн саналаа олон нийт болон холбогдох байгууллагад хүргэж байгаа.

Байлдааны ажиллагаа явуулахад шинэ төрлийн зэвсэг зохион бүтээж, зэвсэглэлд авах нь ялалт, амжилтад хүргэх цорын ганц зам биш билээ. Зэвсгээр хөөцөлдөх нь урт хугацаанд улс орныг эдийн засгийн хямралд оруулах нөхцөлийг ч бүрдүүлж болно. Үүний жишээ бол ОХУ билээ. Тиймээс аливаа улсын батлан хамгаалах чадавхыг бүрдүүлж, хөгжүүлэхэд бүх талын нарийвчилсан судалгаа, тооцоо хэрэгцээтэй.

Улс орнуудын батлан хамгаалах төсөв дунджаар дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь байсан. АНУ-ын өнөөгийн засаг захиргааны төрийн бодлого, дэлхийн улс орнуудын хүчний харьцааны өөрчлөлтийн явцын үр дүнд Европын холбооны болон Умард Атлантын гэрээний орнуудын батлан хамгаалах төсөв 5 хувьд хүрэх төлөвтэй байна. Европын холбооны улс орнуудын батлан хамгаалах зардлыг 5 хувь гэж тооцвол энэ нь мөнгөн дүн $2023000000000/100\% \cdot 5 = 1011500000$ евро болох нь. (2025 оны тооцооллоор Европын холбооны ДНБ 20,23 их наяд евро болж байна) Энэ мөнгө цэргийн үйлдвэрлэл рүү, цэргийн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, цэргийн худалдан авалт, түүхий эдийн худалдан авалт, цэргийн хангамж, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ложистикийн сүлжээ, засвар үйлчилгээ, сургалт гэх мэтийн зүйлд зарцуулагдах нь ойлгомжтой.

Дэлхийн худалдаа БНХАУ-Европын холбоо гэсэн төвтэй ч болох хандлагатай байна. Дэлхийн худалдааны тогтолцооны өөрчлөлт, дэлхийн мөнгөний урсгал болон валютын нэршил ч өөрчлөгдөх нөхцөл бүрдэж байна. Энэ нь ОХУ-ны худалдааны хүндрэлийг нэмэгдүүлэхийг үгүйсгэхгүй. Дэлхийн эдийн засгийн хөгжил гацаанд орох магадлал тун их болсон гэж үзэж байна. Дэлхийн дайнаар эдийн засгийн гацааг гаргадаг тул дэлхийн дайн дэгдэх нөхцөл нэмэгдэж байна. Иймд, цэргийн хэргийн хөгжилд улс орнууд их бага, хүчтэй, дорой гэхгүйгээр анхаарах цаг нь болсон. Европын холбооны улсууд үүний жишээ болж байна гэж үзэж байна.

Эргээд одоо өрнөж байгаа Орос-Украины дайны сургамжийг авч үзье. ХБНГУ-ын цэргийн мэргэжилтэн Украины талын ашиглаж буй германы зэвсэглэлийн талаар шинжээчийн дүгнэлтээ гаргасан байдаг. Украины фронтын ангиуд техникийн сул тал, сэлбэг хэрэгслийн олдоц хязгаарлагдмал, засвар үйлчилгээний нарийн төвөгтэй байдлаас болж Германаас нийлүүлсэн хэд хэдэн зэвсгийн системийг засварлаж, ашиглахад боломжгүй байна гэж Германы цэргийн дотоод баримт бичгүүдээс иш татан Spiegel сонин дөрөвдүгээр сарын 10-ны өдөр нийтэлжээ⁵. Орос-Украины дайнд германы 1970-аад онд үйлдвэрлэгдсэн, зэвсэглэлээс хасагдаж байгаа Мардер ЯЦБМ, Леопард 1A5 танк илүү үр дүнтэй ашиглагдаж байна гэжээ.

⁵ <https://kyivindependent.com/ukrainian-troops-face-issues-with-german-weapons-spiegel-reports/>

Шинэ зэвсэглэлийг ашиглах чадвартай бүрэлдэхүүн, тухайн зэвсэглэлийн засвар, үйлчилгээ хийх тогтолцоо, өртөг зэрэг нөхцөлүүд дайны үед эдийн засгийн болон аж үйлдвэрийн хувьд хөгжөөгүй улс оронд төвөгтэй гэдгийг харуулж байна. Иймд, улс орон зэвсэглэлд авч байгаа зэвсэглэл техникийн асуудлыг цогцоор нь засвар үйлчилгээ, ашиглалтын зардал, түүний төсөвтэй хамт шийдвэрлэж байх нэн том шаардлага байна. Шинжлэх ухааны тэргүүлэх ололт, амжилт, түүний үр дүнд бий болсон зэвсэглэл техник нь дайнд ялах нөхцөлийг сайжруулж байгаа болохоос ялалтад хүрэх үндсэн арга зам биш. Өөрийн улс оронд үйлдвэрлэсэн зэвсэглэл техниктэй байх нь чухал байна. Уг зэвсэглэл техник нь Зэвсэгт хүчний хэрэгцээ, шаардлага, үйл ажиллагааны онцлогт дүйцсэн байх, одоо зэвсэглэлд байгаа техниктэй нийцдэг, засвар үйлчилгээ, сэлбэг олдоцтой байх нь зүйтэй. Үүнтэй уялдаж Монгол Улсын цэргийн шинжлэх ухаан хөгжиж байх ёстой. Цэргийн шинжлэх ухааныг чиглүүлэх зөв бодлого, зоригтой шийдэл, орчин үеийн аюулгүй байдлын нөхцөл байдлыг Монголын хөрсөн дээр, мөн болзошгүй энхийг дэмжих цэргийн ажиллагааны газар нутаг дээр зөв үнэлэх нь нэн чухал болсон байна.

Цэргийн хэргийн хөгжлийг бүх шатны удирдах албан тушаалтан хангах хэрэгцээ ч хурцаар тавигдаж байна. Барууны орнуудын аюулгүй байдлын шинжээчдийн хийсэн үнэлгээ, гаргасан магадлалаар дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлын орчны үнэлгээгээр 2027-2030 онд Энэтхэг-Номхон далайн бүс нутагт дайн үүсэх магадлалтай гэсэн цаг хугацааны тоолол ч хаяанд ирлээ. Энэ бүс нутгийн хямрал бүхий дайн болзошгүй цаг хугацаа улам ойртож байгааг манай Зэвсэгт хүчний бүх түвшний удирдлагын албан тушаалтан анхааралдаа авч, цэргийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх хэрэгцээ байна.

Монгол Улсын батлан хамгаалах бодлогоос хамаарч Зэвсэгт хүчний даргалах албан тушаалтныг сонгож бэлтгэх онцлог байгааг анхаарч ажиллах хэрэгцээ байна. Өөрөөр хялбарчилж хэлэхэд, хүний нөөцийг хөгжүүлэхэд бид хөрөнгө оруулалтаа чанаржуулах, нэмэгдүүлэх хэрэгцээ өндөр болсон. Манай Зэвсэгт хүчний даргалах албан тушаалтан сонгомол байлдааны ажиллагаанд суралцахаас гадна, энхийн дэмжих ажиллагаанд оролцох, орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулах, хямралын үед цэргийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахын зэрэгцээ орон нутгийн засаг захиргааны нэгжийн даргын үйл ажиллагааг зохион байгуулах мэдлэгтэй байх шаардлага байна.

Гадаад харилцаа цэргийн хөгжилд хувь нэмэр оруулдаг тул гадаад хэлний өндөр мэдлэгтэй байх шаардлага ч байна. Хэлний мэдлэгийг дагаж тухайн хэлтэй улс орнуудын соёлыг ч бид ойлгох, мэддэг байх нь чухал. Бидэнд англи хэл, орос хэл, хятад хэл, франц хэлний мэдлэгийн хэрэгцээ, шаардлага байна. Хошууч цолтой офицер бүр цэргийн дээд боловсролтой (академи/команд-штабын коллеж дүүргэсэн) байх хэрэгцээ байна. Цэргийн нэгтгэл, анги, байгууллагын штабт ажиллах бүрэлдэхүүн удирдлагын академи (түүнтэй ижил команд-штабын коллеж)-ийг дүүргэснээр удирдах албан тушаалд л томилогдоно гэсэн бодол, хандлага, хүлээлттэй байдаг. Бид эдгээр сургууль төгссөн алба хаагчдыг эхний ээлжид зөвхөн штабын ажилтан гэж үзэх хэрэгтэй. Дараа нь ажил дээрээ ямар үр дүн гаргаж байна, хамт олны дунд ямар байр суурь эзэлж байна, ерөнхий

мэдлэгийн цар хүрээ, сэтгэн бодох чадвар, бие бялдар, сэтгэл зүй, манлайллын чанар зэргийг харгалзан удирдах албан тушаалд томилох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, команд штабын коллеж төгссөнөөр тухайн алба хаагч штабт ажиллах мэдлэгтэй болсон гэдгийг илэрхийлж буй бөгөөд удирдах албан тушаалд томилогдох нөхцөл нь оюуны, ёс зүйн түвшин, эрүүл мэнд болон бие бялдар, ажлын дадлага туршлага, сэтгэл зүйн зураглал зэрэг болно. Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуулийн цэргийн дээд сургуульд элсэн орж байгаа сонсогчийн ирээдүйн нийгмийн асуудал, ажлын байр, цалин хангамжийг төр засгийн хэмжээнд бусад төрийн албан хаагчдаас илүүтэй тавих шаардлага байна. Энэ нь төр засгийн хувьд хүндхэн ч гэсэн шийдэх л ёстой асуудал. Ингэснээр, ҮБХИС-ийн цэргийн дээд сургуульд сурах сонсогчийн элсэлтийн шалгуур босгыг бусад их дээд сургуульд элсэн орох шалгуураас өндөр болгох хэрэгтэй.

Дараах хэсэгт Цэргийн шинжлэх ухааны нэр томьёоны асуудалд санаа дэвшүүлье. Аливаа шинжлэх ухаан хүлээн зөвшөөрөгдсөн нэр томьёо, хэмжүүрийн үндэс суурьтай байх ёстой. Энэ нэр томьёо ойлголтууд ойлгомжтой, логик уялдаатай байх хэрэгтэй. Нэр томьёо, ойлголтууд гадаад улс орны болон дотоодын цэргийн сургуульд сурч байгаа, төгссөн бүх бүрэлдэхүүнд хамааралтай. Энэ чиглэлээр профессор, чөлөөнд байгаа дэслэгч генерал Ц.Дашзэвэг, Шинжлэх ухааны доктор, профессор Ш.Паламдорж нарын судлаачдын бүтээл болох цэргийн нэр томьёоны толь бичиг хэдэн жилийн өмнө уншигчдын гар дээр хүргэгдсэн. Энэ бүтээлийг дахин хянаж, ШУА-ийн Монгол хэлний хэл судлалын төвийн хурлаар оруулж батлуулж, албан ёсны болгох нь чухал байна. Ингэснээр, бид үгэн дээр тоглох, хэн нэгнийгээ дээш доош болгох, барууны цэргийн сургууль төгссөн, оросын цэргийн сургууль төгссөн, дотоодын цэргийн сургууль төгссөн гэх хагарлыг таслан зогсоох шаардлагатай. Бид үг дээр бус, асуудлын агуулгыг харж, ойлголцож, шийдвэрээ гаргаж, гаргасан шийдвэрээ хэрэгжүүлдэг байх ёстой. Бид цөөхүүлээ, 3,5 сая монголчууд, мөрдөстэй нь хэд билээ, Монгол Улсынхаа төлөө зүтгэж байгаа.

Орчуулгын нэгдсэн ойлголттой байх ач холбогдлыг дараах нэр томьёон дээр жишээ болгож үзье. Үүний өмнө монгол хэлний тайлбар толь бичгээс чадавх, чадамж, чадал, чадвар гэсэн үгийн тайлбарыг авч үзье. Тайлбар толь бичгээс үзэхэд чадавх болон чадамж, чадал болон чадвар ижил утгатай үгс болж байна.

Чадавх=чадамж. Чадах боломж, хэмжээ: **чадамж муутай** (тухайн зүйлийг хийж чадах боломж, бололцоо муутай), **чадамж сайтай** (тухайн зүйлийг хийж чадах боломж сайтай);

Чадал=чадвар. Эрдэм мэдлэг, чадвар, ид хав: чадал заах (эрдэм мэдлэг, чадвараа гаргах), **чадал чансаа** [хоршоо] (мэдлэг чадвар, боломж, ур чадвар) - Үсэг бичгийн чадал чансаа, хурдан бичилтийг нь дээр өгүүлсэн билээ. **мэдэл чадал** [хоршоо] (а. Эрдэм мэдлэг; б. Эрх мэдэл), **чадал эрдэм ~ эрдэм чадал** [хоршоо] (мэдлэг чадвар) - Хэдийгээр чадал эрдэмгүй боловч зоригтой юм. Гурван улсын үлгэр., **ид чадал** [хоршоо] (ид хав, хүч тэнхээ), **чадал дадал** (аливаа зүйлийг хийж гүйцэтгэх чадвар дадлага), **ур чадал** [хоршоо] (урлах чадвар) гэж тайлбарлагдаж байна.


Тэгвэл галын боломж гэсэн нэр томьёо хэрхэн орчуулагдах боломжтой вэ?

гэдгийг авч үзье. Огневая возможность - галын чадвар (интернэтийн google орчуулга) - галын боломж.

Дараагийн жишээ болгож “байлдааны чадавх” цэргийн нэр томъёог авч үзье.

Барууны хөгжилтэй гэсэн орнуудын Зэвсэгт хүчинд байлдааны чадавх, боломжийн үнэлгээг гал, маневр (хөдөлгөөн), хамгаалалт/цэргийн аюулгүй байдал, удирдлага гэсэн хэмжүүрийн нэгдэл.

Оросын цэргийн сургууль нь цэргийн байлдааны чадвар/боломж нь Зэвсэгт хүчний бэлэн байгаа нөөц, тавигдсан байлдааны үүргийг гүйцэтгэх, байлдааны ажиллагааг амжилттай явуулах нөхцөлийг бүрдүүлж буй материаллаг болон сэтгэл зүйн чадавхын нэгдэл гэж тодорхойлсон байна⁶ (Зураг 1).



Зураг 1. Байлдааны чадавх/боломжийн тодорхойлолтын харьцуулалт

Зураг 1 дээрээс үзэхэд даргын шийдвэр гаргахад барууны орны цэргийн

⁶ Боевой потенциал - это совокупность имеющихся средств, а также материальных и духовных возможностей вооруженных сил, формирующих их способность эффективно выполнять стоящие перед ними боевые задачи, успешно вести военные (боевые) действия. <https://encyclopedia.mil.ru>

сургуулийн өгч буй мэдээлэл 4 ангилалд багцлагдсан байна: гал, маневр, цэргийн хамгаалалт/цэргийн аюулгүй байдал, удирдлага. Оросын цэргийн сургуулийн аргачлалаар шийдвэр гаргаж буй даргад мэдээлэл задгайгаар очиж байна. Багцлагдсан мэдээлэл дээр үндэслэн шийдвэр гаргах нь илүү хялбар ойлгомжтой байна. Нөгөө талаас, оросын цэргийн сургуулийн аргачлалаар дарга бүх анхан шатны өгөгдлүүдийг сонсож өөрийн гэсэн дүгнэлт гаргах хэдий ч шийдвэр гаргах даргын цагийн төлөвлөлт нь их хугацаатай байна.

Нэр томьёо хэллэгийг боломжийн хэмжээнд цэгцлэгдсэний дараа бид нэг “хэлээр” хоорондоо ярилцаж ойлголцоно.

Байлдааны дүрэмд зарим тодотгол хийх хэрэгцээ байна. Жишээ нь, цэргийн дарга өөрөөсөө хоёр шат дээш гүйцэтгэх үүргийн талаар мэдээлэлтэй байх ёстой гэж байлдааны дүрэмд тусгасан байдаг. Энэ нь орчин цагийн байлдааны ажиллагаа явуулах Монгол Улсын төрийн цэргийн байгууллагын бүрэлдэхүүнд хангалттай бус гэж үзэж байна. Сонгомол байлдааны болон цэргийн ажиллагаа явуулж байх үед энэ шаардлага зүйтэй байж болно. Харин орон нутгийн хамгаалалт дээр суурилж байлдааны ажиллагаа явуулахад 2 шат дээгүүр ажиллагааны мэдээлэл хангалттай бус байна. Энэ орон нутгийн хамгаалалт дээр суурилсан байлдааны ажиллагаа нь хосолмол/холимог/гибрид байлдааны ажиллагаа болно. Газар орон дээр байлдааны ажиллагаанд оролцож байгаа төрийн цэргийн болон орон нутгийн цэргийн даргалах бүрэлдэхүүн зэрэгцээ орших хоёр өөр удирдлагын тогтолцоо (цэргийн болон орон нутгийн цэргийн)-ны талаар зөв мэдлэгтэй байх шаардлагатай.

Стратегийн төлөвлөлт, түүний хэрэгжилтийг хангах нь улсын төсвөөс нэлээдгүй хэмжээний санхүүжилт шаардана. Иймд, том стратеги төлөвлөлт бодитой болж байгаа эсэхийг шалгахад төсөв мөнгө шаардлагатай. Өнөөгийн нөхцөлд бид төрөл бүрийн түвшний команд-штабын сургуулиар төлөвлөлтийн хэрэгжих боломжийг ихэвчлэн шалгаж байна. Үүний үр дүнд, тактикийн сургуулиар цэргийн урлагийг хөгжүүлэх оролдлого хийгээд байна уу? Эсвэл өөрсдийгөө хуурч байна уу? гэсэн асуудалд бид бодитоор хариулах хэрэгтэй.

Цэргийн урлагийг хөгжүүлэхэд бидэнд шинжлэх ухааны үндэслэлтэй бүтээлч сэтгэлгээ хэрэгтэй. Түүнчлэн цэргийн урлагийн хөгжилд Зэвсэгт хүчний гүйцэтгэх үүргийн зөв ойлголт, стратегийн сэтгэлгээ, цэргийн хэргийн мэдлэгээс гадна ерөнхий эрдмийн өргөн цар хүрээний мэдлэг зэрэг нөхцөлүүд өөрийн тусгалаа олдог билээ.

Удирдах албан тушаалд бид ёс зүй болон ажил хэрэгч байдлыг харгалзахын оронд надад хэр үнэнч вэ? гэсэн байр сууринаас сонголт хийж томилгоо хийж байгаа нь бүтээлч, стратегийн түвшний бүтээлч техник сэтгэлгээтэй удирдагчийг бэлтгэхэд бэрхшээл үүсгэж байна. Энэ нь зөвхөн манай улсад тохиож байгаа зүйл биш байна.

Цэргийн даргын сэтгэлгээний хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна. Байлдааны дүрэмд давшиж буй тал хүчний (бие бүрэлдэхүүний, зэвсэглэл техникийн хувьд гэх мэтчилэн) 3-10 дахин илүү хүч хэрэгслийг төвлөрүүлж амжилтад хүрдэг ойлголт өөрчлөгдсөн. Давшиж буй тал 0,9 хориглогч тал 1,0 харьцаатай байх хандлага

ердийн мэт болж байна.

Энэ харьцаа 17 дугаар зуунаас эхлэн дайны талаар судалгаа хийсэн Хаант Оросын генерал Головины “Дайны тухай шинжлэх ухаан” номонд “Цэргийн судлаачид дэлхийн I дүгээр дайны талаар давшиж буй болон хориглож буй талуудын харьцааны талаар судалгаа хийсэн байна. Отто Берндт ялалтад хүрэхийн тулд тоон давуу байдал чухал болохыг авч үзэхдээ дараах дүгнэлтэд хүрчээ. “78 томоохон тулалдаанд (Долоон жилийн дайн ба 19-р зууны дайн) байлдагчдын хүч тав дахин илүү байв. Үлдсэн 73 тулаанд хамгийн хүчтэй нь 40 удаа, хамгийн сул нь 33 удаа ялалт байгуулжээ. 17, 18, 19 дүгээр зууны томоохон тулаануудын талаарх ижил асуултыг судалж үзээд Гастон Бодарт арай өөр дүгнэлтэд хүрчээ. Энэ гурван зууны хугацаанд болсон 201 томоохон тулалдаанд 10 тохиолдолд байлдагч талуудын хүч тэнцүү байв. Үлдсэн 191 тулаанд хамгийн хүчтэй нь 97 удаа, хамгийн сул нь 94 удаа ялжээ.”⁷ гэж бичсэн байна. Мөн АНУ тэргүүтэй эвслийн цэргийн “Цөлийн шуурга” (1990-1991 он) цэргийн ажиллагаанд давшигч тал хориглогч талын бие бүрэлдэхүүний тоон харьцаа 900 мянга/1,5 сая байсан. Энд эвслийн цэргийн нисэх хүчин, холбооны болон бусад техник, технологийн давуу талууд байсан.

ДҮГНЭЛТ

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, батлан хамгаалах бодлого нь үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурлан шинэчлэгдэж байхын зэрэгцээ, эдгээртэй холбоотойгоор цэргийн хэргийн хөгжил ч тогтмол урагшлах шаардлагатай. Монгол Улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдлийг хадгалах, эдийн засаг, соёл, хүний эрхийг хамгаалах нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үндсэн зорилго болдог бөгөөд үүний төлөө цэргийн хүчин чадлыг хөгжүүлэх, оновчтой стратеги боловсруулж хэрэгжүүлэх нь чухал гэдэг нь ойлгомжтой байна.

Шинэ санаачилга гаргах чадвар, дасан зохицох уян хатан чанар нь түүхийн аливаа үе шатанд амжилт, ялалтын үндэс болж байсан. Өнгөрсөн үеийн сургамжаас суралцах нь чухал боловч, түүнийг яг тэр хэвээр нь дагах бус, ухаалаг байдлаар дүгнэж, ирээдүйд тохируулан хэрэгжүүлэх нь эрхэм чанар юм. Мөн хиймэл оюун ухааны хөгжлийн үед хиймэл оюун ухааны гаргаж буй саналыг тунгаан дүгнэх чадвартай даргалах бүрэлдэхүүн агаар мэт хэрэгцээтэй болох цаг ирсэн байгааг энд онцлох ёстой.

Цэргийн бодлого, цэргийн шинжлэх ухааны үйл ажиллагааны чиглэл гэсэн дарааллаар цэргийн хэргийн өрнөл явдаг. Харин манай улсад дэс дараалалгүй, залгамж холбоогүй олон үйл ажиллагаа хаанаас л бол хаанаас явагддаг сул тал байна. Мөн цэргийн шинжлэх ухааны нэр томьёоны асуудал чухал үүрэгтэй. Түүнчлэн олон улсын жишиг, гадаад хэлийг эзэмших, цэргийн сурах бичиг, ойлголтын нэг стандарт, хэллэг боловсруулах нь үндэсний цэрэг-техникийн хөгжил, ойлголцлыг дээшлүүлэх, уялдуулахад чухал байна. Энэ нь цэрэг-техникийн шинэчлэл, цэргийн боловсролын тогтолцоонд цогцоор нь анхаарах шаардлагыг бий болгож байна.

⁷ Наука о войне (о социологическом изучении войны), Головин Н.Н. <https://www.klex.ru/rs9>

Оросын нэрт цэргийн зүтгэлтэн А.И. Свечиний хэлсэн үгээр өгүүллээ дуусгая. “Цэргийн хэргийн бодлын хамгийн том гавьяа бол түүний оюун ухааны тунгалаг байдал, хэрэгжих бодит байдал, бодит нөхцөл байдлаас тусгаарлагдаагүй байдал юм.” Энэ үг цэргийн ухааны гүн гүнзгий мөн чанарыг гайхалтай онцолсон байна. Стратеги, шийдвэр гаргалт нь зөвхөн онол төдий байж болохгүй, бодит байдал, нөхцөл байдлын нарийн тооцоотой хослох ёстойг онцгойлон сануулж байна. Бодит байдал, хэрэгжих боломжийг харгалзан үзсэн шийдлүүд л урт хугацаанд амжилттай хэрэгжих үндэс болдог.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. <https://kyivindependent.com/ukrainian-troops-face-issues-with-german-weapons-spiegel-reports/>
2. Боевой потенциал - это совокупность имеющихся средств, а также материальных и духовных возможностей вооруженных сил, формирующих их способность эффективно выполнять стоящие перед ними боевые задачи, успешно вести военные (боевые) действия. <https://encyclopedia.mil.ru>
3. Монгол Улсын Батлан Хамгаалах Бодлогын Үндэс <https://legalinfo.mn/mn/detail?lawId=206917&showType=1>
4. Монгол Улсын Батлан Хамгаалах Бодлогын Үндэс <https://legalinfo.mn/mn/detail?lawId=206917&showType=1>
5. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал <https://legalinfo.mn/mn/detail?lawId=18>
6. Наука о войне (о социологическом изучении войны), Головин Н.Н. <https://www.klex.ru/rs9>
7. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль, Төрийн дуулал <https://legalinfo.mn/mn/detail?lawId=496>